

LXX

**ХРИСТОФЕР КОЛУМБА АМЕРИК ТИВИЙГ НЭЭСНИЙ 500
ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛСАН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ
БАГА ХУРЛЫГ НЭЭЖ, МОНГОЛЫН АНУ СУДЛАЛЫН
ТӨВИЙН ТЭРГҮҮН Н.ИШЖАМЦЫН ХЭЛСЭН ҮГ**

1992-10-10

**Эрхэм хүндэт эрдэмтэн мэргэд!
Эрхэм хүндэт зочин гийчдээ!**

Өнөөдөрт бид Америк тивийг анх нээсний 500 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний Бага хурал хийж байна.

1492 оны 10-р сарын 12-ны өглөө Христофер Колумба тэргүүтэй Испани, Португалийн далайчид Америкийн зүүн эрэг дээр бууснаас хойш Европ, Ази, Африкийн улс орнууд тэртээ хол бас нэг их эх газар байдгийг мэдэж, тэндхийн оршин суугчдын тухай бодитой мэдээ авах болсон юм. Америкт хэдэн арван мянган жилийн өмнө Төв ба Зүүн Хойт Азиас хүмүүс очиж оршин амьдрах болсон, Европ Азийн зарим далайчид Колумбаас өмнө тэнд хүрч байсан баримт байдаг боловч Америк тивийг шинэ цагийн шинжлэх ухаанд нээж, дэлхий нийтийн хөгжил, орчин үеийн соёл иргэншилд татан оруулсан нь анх чухамхүү Колумбын нээлтээр эхэлсэн байна.

Америк тивд Баруун Европоос олон хүн очиж, анхны үест уугуул иргэд, тэдний өвөрмөц соёл иргэншилд багагүй хор хохирол учруулсан ч гэсэн цаашдаа АНУ зэрэг өндөр хөгжилтэй улс орнууд бий болж, дэлхий нийтийн хөгжил, орчин үеийн соёл иргэншилд ихээхэн чухал нөлөө үзүүлсэн юм.

1987 онд Монгол, Америкийн хооронд дипломат харилцаа тогтоож, 1989-90-ээд оны үеэс эхлэн Монгол, Америкийн харилцаа, хамтын ажиллагаа амжилттай өрнөх төлөв нээгдлээ. Монгол улс ардчилал, олон намын систем; зах зээлийн тогтолцоонд шилжин, дэлхий нийтийн хөгжлийн нийтлэг зам дээр гарах явдалд АНУ тууштай тусламж дэмжлэг үзүүлж байгааг цохон тэмдэглэхэд таатай байна.

Монгол, Америкийн ард түмний харилцан ойлголцож, хамтын ажиллагаагаа улам өргөжүүлэн бэхжүүлэхэд тус тусын орны түүх, соёл, зан заншлыг мэдэх явдал чухал ач холбогдолтой. Тийм сонирхолтой түүхэн үйл явдлын нэгэнд Колумбын нээлт, түүний үйл ажиллагааг хамгааруулж бүрэн болох байна. Тухайлбал, ХШ-Х1Ү зууны Монголын эзэнт гүрний үед Монгол ба Европ, Өрнө-Дорнын хооронд торгоны их замын салаа салбар, хуурай замын өртөө буудал байнга ажиллаж, эдийн засаг, соёл, шашны харилцаа нөлөөдл

чөлөөтэй нэвтэрч байсан бол эзэнт гүрэн задарч мөхсөний дараа тийм боломж алдагдсан байна. Х1Ү-ХҮ зууны Баруун Европын капиталист сэргэн мандалтын үеийн худалдаачин жуулчдын зарим нь дэлхий бөөрөнхий болохыг зөвшөөрөн хүлээж, Монгол, Хятад, Энэтхэг, Япон, Зүүн Өмнөд Азийн тухай Марко Пологийн замын тэмдэглэлийг анхаарч судлан, тэдгээр улс оронд Баруун Европоос өрнө зүг гадаад далайгаар аялан хүрч болно гэдэг дүгнэлтэд хүрч байжээ. Ялангуяа Колумба тэр санаанд бат итгэж, зориг шулуудан аялаад Америкт хүрснээ Энэтхэгт очлоо гэж бодоод нутгийн хүмүүсийг индиан нар буюу энэтхэгчүүд гэж нэрлэсэн. Тэгээд улмаар Хубилай хааны нийслэлд хүрч очих оролдлого хийж байсан байдаг. Энэ бүхэн нь Колумбын нээлт, түүний үйл ажиллагаа Монгол, Америкийн түүхтэй ямар нэг холбоотой болохыг давхар нотолж байна. Тиймийн учир Монголд Колумбын нээлтийн ойг анхаарч сонирхох, түүхэн үндэс ч бас байгаа юм.

Ялангуяа Монгол, Америкийн харилцаа, хамтын ажиллагаа ид өрнөж эхэлсэн өнөө үед Америкийг нээсний 500 жилийн ойгоор тохиолдуулан эрдэм шинжилгээний бага хурал хийж, тэрхүү түүхт ойг тэмдэглэж өнгөрүүлэх нь нэн зохимжтой, цаг үеэ олсон явдал гэж бидэнд бодогдож байна.

Ингээд эрдэм шинжилгээний бага хурлын үйл ажиллагаа нээснийг мэдэгдье.